

“СҮХ-ИНДЭР” ХХК

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ЗҮҮН-ӨЛЗИЙТ” НЭРТЭЙ БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/ Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 3375099 /

/ Тусгай зөвшөөрлийн дугаар: ДО-004А /

Улаанбаатар хот
2022 он

“СҮХ-ИНДЭР” ХХК

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ЗҮҮН-ӨЛЗИЙТ” НЭРТЭЙ БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/ Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 3375099 /

/ Тусгай зөвшөөрлийн дугаар: ДО-004А /

ХЯНАСАН:

“БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ Ц.ЖАРГАЛНЭМЭХ /

Биелэлтийг тайлагнасан:

“СҮХ-ИНДЭР” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн:

Н. Цолмон

/ Н.ЦОЛМОН /

Улаанбаатар хот

2022 он

ГАРЧИГ

БҮЛЭГ I. ОРШИЛ	3
БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
II.1. Төслийн нэр	4
II.2. Төсөл хэрэгжүүлэгч	4
II.3. Төслийн байршил	4
Зураг. “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг	5
II.4. Уурхайн нөөц	5
II.5. Хүчин чадал	5
II.6. Уурхайн ажлын горим	5
II.7. Ашиглалтын систем	6
II.8. Уурхайн тээвэр	6
II.9. Хөрсний овоолго	6
II.10. Уурхайн тэсэлгээ	6
II.11. Төслийн дэд бүтэц	6
II.12. Ил уурхайн хэмжээс, процесс	7
БҮЛЭГ III. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
БҮЛЭГ IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
V.I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
V.II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	17
V.III. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
V.IV. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	19
V.V. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	19
V.VI. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	19
V.VII. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	24
V.VIII. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	27
V.IX. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	30
V.X. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	31
V.XI. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	32
ДҮГНЭЛТ	35
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	36

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол	4
Хүснэгт 3. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүд	6
Хүснэгт 4. Төслийн нийт усны хэрэглээ	7
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	19
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	27
Хүснэгт 10. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт	30
Хүснэгт 11. Химийн бодисын эрсдэлийн үнэлгэний төлөвлөгөөний биелэлт	31

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт.....	32
Хүснэгт 13. 2022 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг.....	5
Зураг 2. Уурхайн замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал.....	14
Зураг 4. Өнгөн хөрсийг овоолго байдлаар хадгалсан байдал	15
Зураг 5. ШТМ-ыг хадгалах зориулалтын сав	15
Зураг 6. Ундны ус нөөцлөх сав	16
Зураг 7. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөхөн сэргээлт хийсэн байдал	18
Зураг 8. Гал унтраах багаж, хэрэгслийг байршуулсан байдал	21
Зураг 9. Гал түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулах санамж, тэмдэг	21
Зураг 10. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал	22
Зураг 11. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал	22
Зураг 12. Хөдөлмөр хамгааллын сургалт явуулж буй байдал	23
Зураг 13. Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж байгаа нь	23
Зураг 14. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаажуулсан байдал	25
Зураг 15. Хог тээвэрлэлтийн гэрээ	26
Зураг 16. Хөдөлмөр хамгааллын сургалт зохион байгуулж байгаа нь	28
Зураг 17. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсар хангасан байдал	28
Зураг 18. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангаж буй нь.....	29
Зураг 19. Галын аюулаас сэргийлэх анхааруулах самбар	29

БҮЛЭГ I. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах аргачлал:

Тус төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Зүүн-Өлзийт” Барилгын чулууны ордын БОМТ-ний биелэлтийн тайланд 2022 онд нийт **31,516,500.00** төгрөг зарцууллаа.

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Сүх-Индэр” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		0711006136
3	Уурхайн нэр “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны орд ашиглах төсөл		
4	Ордын	Нийслэл/Хот/ Аймаг	Дорнод аймаг
5	байршил	Сум/Дүүрэг	Хэрлэн
6	Ашигт малтмалын төрөл		Барилгын чулуу
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		ДО-004А
8	Аж ахуйн	Аймаг/Хот	Дорнод аймаг
9	нэгжийн	Сум/Дүүрэг	Хэрлэн
10	хаяг	Баг/Хороо	1-р баг
11	Захирлын	Нэр	Захирал Э. Энхболд
12	хаяг	Гар утас	976-99992068

II.1. Төслийн нэр

“Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны орд ашиглах төсөл

II.2. Төсөл хэрэгжүүлэгч


“Сүх-Индэр” ХХК

II.3. Төслийн байршил

“Зүүн-Өлзийт” барилгын чулууны орд нь Дорнод аймгийн төв болох Чойбалсан хотоос зүүн тийш 18 км-т, Хэрлэнгийн зүүн гүүрнээс 15 км-т Хэрлэн голын урд талд байрладаг. Хайгуулын талбай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 658 км зайд байрлана.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	114	40	59.60	48	05	57.10
2	114	40	59.60	48	06	15.60
3	114	41	21.50	48	06	15.60
4	114	41	21.50	48	05	57.10



Зураг 1. “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын байршлын зураг

II.4. Уурхайн нөөц

Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордод эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж улмаар 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Уул Уурхайн Яам, Ашигт Малтмалын Газрын Тосны Газрын дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитой (В) зэрэглэлээр 3,008,942.5 м³ буюу 7,432,088.0 тн, боломжтой (С) зэрэглэлээр 2,367,224.8 м³ буюу 5,847,045.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 5,376,167.3 м³ буюу 13,279,133.3 тн барилгын чулууны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

II.5. Хүчин чадал

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Сүх-Индэр” ХХК-ийн “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордыг 82 жилийн хугацаанд ашиглах бөгөөд жилд 36.0 мян.м³ барилгын чулуу олборлох ба бутлан ангилах хэсэгт сийрэгжүүлснээр 50.4 мян.м³ барилгын чулуу боловсруулах хүчин чадалтай.

II.6. Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь 4 сараас 9 сарыг дуустал тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын

хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон. Хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. Жилд 110 хоног ажиллана.

II.7. Ашиглалтын систем

Ордыг ил аргаар нээж, ашиглах бөгөөд тэсэлгээтэй, авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

II.8. Уурхайн тээвэр

Хүснэгт 3. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүд

Тоног төхөөрөмийн төрөл	Марк	Ш/тоо
Үндсэн тоног төхөөрөмж		
Утгурт ачигч	Long Yu ZL 935	1
Экскаватор	CAT330	1
Автосамосвал	Howo	2
Туслах тоног төхөөрөмж		
Суудлын машин	Pick up	1
Зам услагч	Foton	1
Түлшний машин	Hyundai	1
Микро автобус	Hyundao istana	1
Ачааны машин	Hyundai Mighty	1

II.9. Хөрсний овоолго

Шимт хөрсийг Long Yu ZL935 маркийн утгуурт ачигчаар хуулна. Шимт хөрсийг ил уурхай, бутлан ангилах хэсгийн талбай, уурхайн гадаад тээврийн замын талбай, хөрсний овоолгын суурийн талбайгаас 0.2 метрийн зузаантайгаар хуулна. Нийтдээ эхний 5 жил цулаар 3,148.0 м³ буюу сийрэгжсэнээр 3.777.6 м³ шимт хөрс хуулж овоолно.

II.10. Уурхайн тэсэлгээ

“Зүүн-Өлзийт” нэртэй Барилгын чулууны ордын жилд хуулах уулын цулын хэмжээ бага учир тэсэлгээг жилд нэг удаа хийнэ.

II.11. Төслийн дэд бүтэц

Цахилгаан хангамж

“Дорнод аймгийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 6 кВ-ийн агаарын шугамаас 400 кВт-ын хүчин чадалтай дэд станц угсарч ЦЭХ-ээр хангана.

Усан хангамж

“Сүх-Индэр” ХХК нь унд ахуйн усны хэрэгцээ болон зам усалгаагаа өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана.

Унд ахуйн хэрэглээнд хэрэглэх усны хэмжээ. Уурхайн хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд жилд 39.6 м³ 82 жилийн хугацаанд 3247.2 м³ ус хэрэглэхээр байна.

Зам усалгаанд ашиглагдах усны хэмжээ. Зам усалгаанд жилд 748.8 м³ нийт 82 жилийн хугацаанд 61,401.6 м³ ус ашиглахаар байна.

Хүснэгт 4. Төслийн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийт ашиглалтын жилд
1	Унд, ахуйн усны хэрэгцээ	м ³	3,247.0
2	Зам талбайн усалгаа	м ³	61,401.6
Нийт усны хэрэгцээ		м³	64,648.6

II.12. Ил уурхайн хэмжээс, процесс

- ✓ Ил уурхайн үйл ажиллагаа нь шимт хөрсийг түрж хуулах-овоолох, өгөршсөн хөрсний үеийг экскаватороор хуулж автосамосвалаар тээвэрлэн хөрсний овоолгод овоолсны дараагаар барилгын чулуу буюу дацит чулуулагт өрөмдлөг-тэсэлгээ хийж гүйцэтгэнэ.
- ✓ Тэслэгдсэн чулуулгийг ухаж ачин тээвэрлэн бутлуурын хажууд түр овоолгод овоолох бөгөөд бутлуурлуу чулуулгийг утгуурт ачигчаар хийнэ.
- ✓ Барилгын чулуу тээвэрлэлт. Ил уурхайгаас олборлож боловсруулсан барилгын чулууг худалдан авагчид Хэрлэн суман дахь “Сүх-Индэр” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрт нийлүүлнэ.

БҮЛЭГ III. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Сүх-Индэр” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

Тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Зүүн-Өлзийт” нэртэй барилгын чулууны ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

“Сүх-Индэр” ХХК нь нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах ажлууд болох тоосжилт үүсэх үед усалгаа, өнгөн хөрсний овоолго, замыг тогтмол нэг маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээ, ШТМ-ын зориулалтын сав байршуулах, дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагаас авсан саналын дагуу хийх, хог тээвэрлэлтийн гэрээ байгуулах, хог хаягдлын цэгийг хашаажуулах, хөрс, усны шинжилгээ хийх, галаас хамгаалах багаж хэрэгсэл, галаас сэргийлэх самбар тэмдгийг шаардлагатай газруудад байршуулах, хөдөлмөр хамгааллын сургалт зохион байгуулах, жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

БҮЛЭГ IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт байрлах “Сүх-Индэр” ХХК нь ДО-004А тоот тусгай зөвшөөрөл бүхий 25.9 га талбайтай. Барилгын чулууны орд”-ыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлнэ.

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайд төсөл хэрэгжих 30 жилийн турш бутлан ангилах шигших тул талбайн ойр орчмын газрын гадаргыг тоос дарж хөрс, ургамал, орчныг бохирдуулна. Мөн өрөмдлөг тэсэлгээний үед ялгарах их хэмжээний тоос орчныг бохирдуулна.

Шимт хөрсийг 0.15-0.2 м зузаантайгаар хуулж хүний хөлөөс зайдуу салхины нөмөр газар 8-10 метрийн өндөртэй байгуулна. Шимт хөрсний овоолго үүсгэсний дараа хөрс нь сийрэгжсэн байх учир салхинд хийсэх, бороо болон үерийн усанд урсах зэрэг сөрөг нөлөөтэй.

Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл: Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадаргад бохирдол үүснэ. Хэдийгээр дунд хугацаанд нөлөөлөл үзүүлэх боловч төслийн хугацаа дуусахад эргэн нөхөн сэргээгдэх боломжтой.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Замын хөдөлгөөн, тэсэлгээ хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын тоосжилт, дизель түлшээр ажилладаг машин механизм тоног төхөөрөмж, тэсэлгээнээс үүссэн бохир хий утаа, дуу чимээ, хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уул уурхайн ашиглалтын болон боловсруулах үйл ажиллагаанд түлш, тос тосолгооны материал, тэсрэх бодис зэрэг аюултай бодисуудыг ашиглахаар байна. Хөрсний гүний усны үеүдэд шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, тэсрэх бодис, бохир усны алдагдал, нэвчилтээс бохирдох эрсдэл үүсч болзошгүй учраас уурхайн зүгээс аюулгүй ажиллагааны дүрмийг сайтар баримтлан ажиллах нь зүйтэй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Олборлолтын явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөнө. Их хэмжээний үржил шимт хөрс болон “Зүүн-Өлзийт” нэртэй барилгыг чулууны ордоос эрүүл талбай хөрсний овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүснэ. Газрын хэвлийд хоосон хөндий орон зай үүснэ. Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулна. Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүснэ. Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт,

засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Ил уурхайн талбайд байсан ургамал устана. Уурхайд олон янзын зориулалтаар машин техник ашиглаж, тэдгээрээс үүдэн олон салаа зам үүсч бий болох магадлалтай. Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадаргад шороо тоос үүсч, улмаар салхи шуурганд хийсэн ойр орчмын ургамал бүрхэвч, төслийн талбай тоос шороонд дарагдаж болзошгүй. Байгууламжууд баригдах талбай нь төслийн хугацаанд хүний хөлөөр болон тээврийн хэрэгслээр талхлагдаж бүрэн өөрчлөлтөнд орно. Тосгоноос ахуйн хог хаягдал их хэмжээгээр үүсч, хадгалах зайлуулах стандарт, дүрэм, журам барьж ажиллаагүйгээс гадаргад бохирдол үүсч болзошгүй. Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол үүснэ. Тоосжилт үүссэнээс ойр орчмын ургамлууд дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго хийх, барилга байгууламж барих, техник хэрэгсэл явах зам тавих, кемп барьсны улмаас эдгээр үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болно. Олборлолт явуулсны улмаас хөрс хуулж овоолго хийгээд орхисон байгаа ба овоолго болон түүний орчмын талбайн амьтан, тэдгээрийн амьдрах орчин үгүй болжээ. Цаашид талбайг тэлэх тутам амьтны аймагт учрах хохирол нэмэгдэх болно. Үүссэн овоолгод техникийн болон биологийн нөхөн сэргээлт тухай бүр хийхгүйгээс тус нутгийн амьтны аймаг нөхөн сэргэх хугацаа сунжирна.

Тээврийн хэрэгсэл, тэсэлгээний үеийн дуу чимээнээс хүн амьтан үргэж, дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, ая тухгүй болно. Хөрс хуулалт, овоолго хийх, зам, барилга байгууламж барихад тухайн газрын амьтны аймаг устана. Шавжны аймгийн тархалт байршилд өөрчлөлт гарна. Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтдын зүйлийн тоо толгой ихсэх магадлалтай.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл: “Сүх-Индэр” ХХК-ийн ашиглалтын 25.9 га талбайд ямар нэгэн түүх соёлын дурсгал илрээгүй байна. Ашиглалт явуулах 25.9 га талбайд ямар нэгэн түүх, соёлын ямар нэгэн дурсгалт зүйл илрээгүй боловч олборлолтын үед газар дээр ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож, энэ тухай дүүрэг, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагуудад нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийн хугацаанд уурхайн нарийн мэргэжил шаардагдахгүй ажилд орон нутгийн иргэдээс ажиллуулах ба цөөн хэдэн хүнийг ажлын байраар хангах бөгөөд олборлолтын хугацаанд нутгийн иргэдээс өргөн хэрэглээний бараа, хүнсний тодорхой бүтээгдэхүүн (мах, цагаан идээ, гурил, будаа мөн ариун цэврийн бүтээгдэхүүнүүд г.м) худалдан авах зэргээр бага хэмжээний орлогыг нутгийн иргэдэд оруулах юм.

Ажилчдын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна. Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

V.I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг/
Агаарын орчин			
1	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийх, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Тээврийн хэрэгслийг тохиргоо, засвар үйлчилгээнд тогтмол оруулж байсан. Хөдөлгүүрээс гарах утааны хэмжилтийг стандартын шаардлага хангах арга хэмжээнд байлгасан.	185,000.00
2	Уурхайн олборлолтын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж тогтмол усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Уурхайн олборлолтын үед тогтмол усалгаа хийж байсан.	700,000.00
3	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх	-	-
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийн төлбөрийг төлнө.	Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр, татварыг тогтмол төлж байсан.	185,000.00
Хөрсөн бүрхэвч			
1	Уурхайн хотхон, уурхайн орчмын авто зогсоол явган хүний зам талбайг тохижуулж, машин техникийн хөл хөдөлгөөнд хяналт тавьж, олон салаа зам гаргах болон бусад шалтгаанаар үржил шимт өнгөн хөрс элэгдэж, эвдрэхээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авсан байна.	Уурхайн авто зогсоолыг тохижуулж, дайрган хучилттай болгосон. Уурхайн талбайд олон салаа зам гарахаас сэргийлж, тогтмол нэг маршрутын дагуу тээврийн хэрэгсийг явуулж байсан.	-

2	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахгүй байх, хориглосон таних тэмдгүүдийг сайжруулах, нэмэгдүүлэх	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулаагүй, замын таних тэмдгийг байршуулсан. Зургийг оруулав.	150,000.00
3	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Өнгөн хөрсийг хуулж, стандартын дагуу овоолго байдлаар хадгалсан. Зургийг оруулав.	1,000,000.00
4	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалсан, ШТМ хөрсөнд асгархаас сэргийлж хяналт тавьж ажилласан. Зургийг оруулав.	-
5	Шатах тослох материалыг хадгалах, түгээх цэгийг тохижуулж хяналтыг сайжруулсан байна	ШТМ-ыг хадгалах цэгийн гадаргууг элс дэвсэж, дайрган хучилттай болгосон.	-
Усан орчин			
1	Унд ахуйн ус болон зам усалгааны усны дээж авч лабораториор шинжлүүлэх	Гүний худгаас усны дээж авч лабораторит шинжлүүлсэн. Шинжилгээний дүнг хавсаргалаа.	ОХШХ-т тусгагдсан.
Нийт дүн			2,220,000.00



Зураг 2. Уурхайн замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Зураг 3. Өнгөн хөрсийг овоолго байдлаар хадгалсан байдал



Зураг 4. Өнгөн хөрсийг овоолго байдлаар хадгалсан байдал



Зураг 5. ШТМ-ыг хадгалах зориулалтын сав



Зураг 6. Ундны ус нөөцлөх сав

V.II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Зүүн-Өлзийт” Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төслийн ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу уулын ажлын нөхцөлөөс хамаарч 2022 онд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй гэж 2022 оны БОМТ-нд төлөвлөгдсөний дагуу нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй болно.

V.III. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг /
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Хэрлэн сумын 5р багын нутаг дэвсгэрт байрлах Төв цэвэрлэх байгууламжийн баруун талд ухагдсан байсан нүхийг 510 метр орчим булж, техникийн нөхөн сэргээлт хийсэн. Зургийг орууллаа.	4,600,000.00
Нийт				4,600,000.00



Зураг 7. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөхөн сэргээлт хийсэн байдал

V.IV. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

V.V. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

V.VI. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Сүх-Индэр” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Нийт зардал, 2022 он /төгрөг/
1	Кемп, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байршуулсан. Зургийг оруулав.	2,163,500.00
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулах	Гал түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулах санамж тэмдгийг ажилчдын байр, оффист байршуулсан. Зургийг оруулав.	1,000,000.00

2	Хүчтэй салхи шуурганы улмаас тоос ихээр босч ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, тоосжилтоос үүсэх бусад нөлөөлөл	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг зогсоож байсан.	-
3	Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажилласан. Зургийг оруулав.	-
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулсан. Зургийг оруулав.	-
4	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан. Зургийг оруулав. Замын анхааруулах таних тэмдгийг шаардлагатай газруудад байршуулсан.	-
Нийт				3,163,500.00



Зураг 8. Гал унтраах багаж, хэрэгслийг байршуулсан байдал



Зураг 9. Гал түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулах санамж, тэмдэг



Зураг 10. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал



Зураг 11. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал



Зураг 12. Хөдөлмөр хамгааллын сургалт явуулж буй байдал



Зураг 13. Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулж байгаа нь

V.VII. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Сүх-индэр” ХХК нь Дорнод аймгийн Хэрлэн сумын ОНӨААТҮГ-тэй хог хаягдлын гэрээ байгуулан ажиллана. Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2022 он /төгрөг /
1	Хог хаягдал /хатуу/	-Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх -Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашааг тохижуулах	“Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-тэй хог тээвэрлэлтийн гэрээ байгуулж тээвэрлүүлсэн. Хог тээвэрлэлтийн гэрээг зургаар оруулж, мөн хавсралтанд хавсаргалаа.	250,000.00
2	Аюултай	2догч түүхий эд авдаг газарт нийлүүлэх	Ашигласан ШТМ-ыг зориулалтын саванд цуглуулж, дүүрэхээр нь ашигласан ШТМ дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлнэ.	-
Нийт дүн				250,000.00



Зураг 14. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашажуулсан байдал

БАТЛАВ
“ЧОЙБАЛСАН ХӨГЖИЛ” ОНӨҮГ
ЗАХИРАЛ /Б. ГЭРЭЛТ-ОД/

БАТЛАВ
“СҮХ-ИНДЭР” ХХК
ЗАХИРАЛ /Г. ГАНБОЛД/

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 07 сарын 01 өдөр

Хэрлэн сум

Нэг талаас “Чойбалсан Хөгжил” ОНӨҮГ (цаашид “А” тал гэнэ), түүнийг төлөөлж хог тээврийн тасгийн зохион байгуулагч Гантөмөр овогтой Ганболд Нөгөө талаас (цаашид “Б” тал гэнэ), түүнийг төлөөлж Х. Даваахүү бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

1. “А”, “Б” талын нийтлэг үндэслэл

1.1. “А”, “Б” талууд нь хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх хөтгөл цэвэр орчинд ажиллаж, амьдрах зорилгоор тогтоосон хуваарийн дагуу хаягдал хогийг цуглуулан тээвэрлэж тогтоосон түр цэгт хадгалах ба аюулгүй орчинд эвэж тээвэрлэхэд хамтран ажиллана.

1.2. Гэрээний хугацааг “А”, “Б” талууд 2022 оны 07 сарын 01-ны өдрөөс 2023 оны 07 сарын 01-ны өдөр хүртэл хугацаатай байгуулав. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

2. “А”, “Б” талын хамтын ажиллагааны удирдлага, хяналт

- “А”, “Б” тал нь гэрээний хэрэгжилт болон талуудын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- Талууд аль нэг талынхаа шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлагнана.

3. Нэг. “А”, “Б” талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

- “Б” тал нь гэрээнд заагдсан хэмжээ, хугацаанд хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
- “Б” тал нь хог хаягдлын хураамж 50,000 /Тавин мянга / төгрөгийг “А” талын Хавн банкны 5405177983 тоот дансанд сар бүрийн 25-ны дотор шилжүүлэх
- “А”, “Б” тал нь “Хог хаягдлын тухай” хуулийн 10 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллана.
- “А” тал нь “А” талд хог хаягдлын хураамжыг төлөөгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй.
- “А” тал хог хаягдлыг гэрээнд заагдсан хугацаанд аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тусгай тоноглонс автомашинаар тээвэрлэнэ.
- “А” тал нь улиралд 1 удаа “Б” талын хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

4. Маргааныг шийдвэрлэх

4.1. Хэрэв маргаантай асуудлаар “А”, “Б” талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг орон нутгийн Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Арбитрт түүний Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

5. Бусад заалт

- “А”, “Б” талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- Хог хаягдлыг тээвэрлэхтэй холбоотой санал, хүсэлтийг байгууллагын 70582832 дугаарын утас болон “А” талд албан бичгээр мэдэгдэх.
- “Б” тал нь хог хаягдлыг зориулалтын хогний саванд хийж байршуулна. /Галд шатахгүй, орчин бохирдуулахгүй байх/

6. Гэрээ хүчин төгөлдөр байх

- “А”, “Б” талууд нь гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.
